

БАТЛАВ:

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ /Д.ОЮУНЦЭЦЭГ/

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

4..... ангийн сургач овогтой

ХУГАЦАА 40 МИНУТ

НИЙТ 24 ОНОО

НЭГ. УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

Санамж: 1. Эхийг анхааралтай ойлгож уншаад даалгаврыг гүйцэтгээрэй
2. Сонгох даалгаврын зөвхөн нэг л хувилбарыг сонгоорой.

Хүүхдийн сэтгэл

Тэр өдөр цаг агаар маш муухай байлаа. Цахилгаан цахилж, бороо хувингаар цутгах мэт орж байв. Бяцхан охин ээжийнхээ дуудахад нойрноосоо сэрээд өглөөнийхөө цайг уун бусад өглөөний нэгэн адил сургууль руугаа алхахаар гарлаа.

Цахилгаан хүчтэй цахилж нүргэлсэн дуу чимээ гарахад охины ээж гэнэт сандран “Охин минь замдаа явж байгаад айх вий дээ” гэж бодон машиндаа санд мэнд яaran суугаад охины араас гарав. Тэгээд охиноо замаар явж байхыг олж харлаа. Охин ойрхон ойрхон алхан явж байна. Харин цахилгаан цахихад дордоо зогсоод тэнгэр өөд харан инээмсэглэж байв. Ингэхийг ээж нь хараад эхэндээ ойлгосонгүй. Ихэд гайхан машинтайгаа дөхөн очив. Тэгээд “Үр минь энэ аймаар бороонд ганцаараа явахдаа айсангүй юу?, цахилгаан цахихаар яагаад тэнгэр өөд хараад байгааг ээждээ хэлээч” гэв. Тэгэхэд охин: “Инээмсэглэсэн юмаа. Яагаад гэвэл бурхан миний зургийг дээрээс авч байна.” гэв.

1. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? \1 оноо

- А. Цахилгаан цахих тухай
- Б. Бороо хувингаар цутгах тухай
- В. Тэнгэр дуугарах тухай
- Г. Охины цагаахан сэтгэлийн тухай

2. Охин яагаад тэнгэр өөд харсан бэ? \1 оноо

- А. Тэнгэр дуугарахад айгаад гарсан
- Б. Зураг авч байна гэж бодоод харсан
- В. Цахилгаан цахилахыг харсан
- Г. Бороо хувингаар цутгах мэт орохыг харсан

3. Зөөлрүүлэх үүргээр орсон “Ь”-тэй үгийг олоорой. \1 оноо

- А. харья
- Б. хэлье
- С. ёгье
- Д. бичье
- Е. харья

4. Үгийг утгаар нь зөв харгалзуулаарай. /1оноо/

- | | |
|----------------------|--------------------|
| 1. Баяр баясгалантай | а. Элбэг хангалуун |
| 2. Дутуу гацуу | б. уйтгар гунигтай |

5. Охины ээж нь яагаад санд мэнд яараад гараад явсан бэ? \1 оноо

- A. Бороо орсоноос
- Б. Тэнгэр дуугарсан тул
- В. Охиноо айхуй гэснээс
- Г. Харанхуйгаас

**6. Эхээс бороо орж байгаа талаар хэтрүүлэн зүйрлэсэн хэсгийг олж бичээрэй.
\1 оноо**

- А. Бурхан зураг дээрээс авч байна.
- Б. Оир ойрхон алхах
- В. Цахилгаан цахиж бороо хувингаар цутгах мэт
- Г. Цахилгаан хүчтэй нүүргэлэх мэт

7. Ээжийн хэлсэн хэсгийг олоорой. \1оноо

- А. Охин минь замдаа явж байгаад айх вий дээ.
- Б. Бурхан миний зургийг дээрээс авч байна.
- В. Үр минь энэ аймар бороонд ганцаараа явахдаа ахисангүй юу?
- Г. Охиноо замаар явж байхыг олж харлаа.

8. Холбоос үгсийг зөв ашиглан өгүүлбэрийг гүйцээгээрэй. \1 оноо

Хүн бүр гарын ариун цэврийн сахих шаардлагатай өдөр болгон
сануулдаг. Яагаад гэвэл гараар дамжин элдэв бохир зүйл хүний биед орж өвчин
үүсгэдэг сайтар гараа угааж хэвших хэрэгтэй.

А. Учраас, гэдгийг Б. гэдгийг, учраас В. тул, гэдгийг Г. бол, нь

9. ГАР СҮНГАХ хэлц үгийн утгыг олоорой. \1 оноо

- А. Бусдад юм өгөх
- Б. Бие биедээ туслах
- В. Хүнээс юм харамлах
- Г. Гараа сунгах туслан

10. Доорх өгүүлбэрт тохирох хувилбарыг олоорой. \1 оноо

Өвөө сар шинээр дэмбэрлийн үг хэлж, гарын хүн бүрт
өглөө.

А. бэлгэ, бэлэг Б. бэлэг, бэлгэ В. билиг, бэлэг Г. билиг, бэлгэ

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Дараах загварт тохирох жишээ тус бүрт нь 1,1ийг биээрэй. /2оноо/

3Г + 3Г= Э

ЭГ + 3Г= -Э

2. Эхийн эхлэл хэсгийг эсрэг утгатай болгон өөрчилж бичнэ үү. \2 оноо\

Тэр өдөр цаг агаар маш муухай байлаа. Цахилгаан цахилж, бороо хувингаар цутгах мэт орж байв. Эсрэг утга

3. Охин ягаад инээмсэглэсэн бэ? / 2оноо/

.....

.....

4. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг тайлбарлаж бичнэ үү. / Зоноо/

Эхлээд

.....

.....

Дараа нь

.....

.....

5. “Зургийн цомог” сэдвээр эх зохион бичээрэй. \ үгийн тоо 50-60\ \ 5 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....